

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/231-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Аудитор: Д.Чулуунцэцэг
	Утас: 7036-2442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. Аудитын тайлан	16-17
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМ ДАХЬ
СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА О.ХИШИГСҮРЭН ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-02-13 № СНА-2023/231-НАСТА-ТУС

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 692,046.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 97.5 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 16,718.2 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар хэмнэсэн байна. Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 193 дугаар тогтоолоор шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын үндсэн цалин, Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1/06 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчийн үндсэн цалингийн хэмжээг тус тус нэмэгдүүлэн тогтоож олгосон байна.

018020015

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 80.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 46,497.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын байрны гадна, дотор сантехникт 190,936.5 мянган төгрөгийн их засварын ажил хийгдсэн бөгөөд уг ажлыг капиталжуулан бүртгэл тайланд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгсгөлөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,756,199.35	12,738,309.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	1,000,000.0
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	1,000,000.0
3121	Төгрөг	00.00	1,000,000.0
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,756,199.35	11,738,309.35
354	Хангамжийн материал	7,756,199.35	11,738,309.35
35410	Бичиг хэргийн материал	1,491,075.35	4,454,235.35
35420	Аж ахуйн материал	5,133,099.00	6,152,049.00
35470	Бусад хангамжийн материал	1,132,025.00	1,132,025.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	542,907,457.28	688,844,544.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	542,907,457.28	688,844,544.45
392	Биет хөрөнгө	532,118,729.49	678,264,149.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	389,499,800.00	580,436,315.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12,005,681.64	-19,770,255.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	90,000,000.00	90,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-32,305,555.55	-42,638,888.87
39205	Машин тоног төхөөрөмж	89,549,234.40	95,739,144.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44,097,009.37	-69,112,432.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,051,819.00	51,051,819.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,732,730.87	-39,036,245.83
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,910,840.00	38,910,840.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,508,318.48	-8,262,477.72
39217	Ном	756,332.00	946,332.00
393	Биет бус хөрөнгө	10,788,727.79	10,580,394.47
39301	Программ хангамж	1,025,000.00	1,025,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-528,472.21	-736,805.53
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	550,663,656.63	701,582,853.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	550,663,656.63	701,582,853.80
51	Засгийн газрын хувь оролцоо	550,663,656.63	701,582,853.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	155,648,199.00	155,648,199.00
51101	Өмч: - төрийн	155,648,199.00	155,648,199.00
512	Хуримтлагдсан үр дүн	139,764,399.38	290,683,596.55
51210	Өмнөх үеийн үр дүн	139,764,399.38	139,764,399.38
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	149,919,197.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	255,251,058.25	255,251,058.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	550,663,656.63	701,582,853.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	584,711,315.00	888,027,465.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,148,515.00	197,470,765.00
120	Нийтлэг татварын бус орлого	74,148,515.00	197,470,765.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө	73,876,419.00	196,173,425.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал	272,096.00	1,297,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	510,562,800.00	690,556,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	510,562,800.00	690,556,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	510,562,800.00	690,556,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	546,743,185.65	737,108,267.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	546,743,185.65	737,108,267.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,085,417.65	673,742,717.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,528,450.00	484,048,017.00
210101	Үндсэн цалин	284,413,588.00	334,979,125.00
210102	Нэмэгдэл	69,283,397.00	112,113,072.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,238,569.00	13,317,031.00
210104	Урамшуулал	16,592,896.00	23,638,789.00
2102	Ажил олгогчоос НДШ	49,831,820.00	60,404,951.00
210201	Тэтгэврийн даатгал	34,583,669.00	41,253,049.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,875,141.00	4,816,146.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,071,703.00	3,852,875.00
210204	Ажилгүйдлийн даатгал	754,665.00	953,031.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,546,642.00	9,529,850.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,869,500.00	36,775,101.00
210301	Гэрэл, цахилгаан	3,077,630.00	3,196,900.00
210302	Түлш, халаалт	20,173,952.00	31,342,851.00
210303	Цэвэр, бохир ус	1,617,918.00	2,235,350.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,401,229.38	25,379,115.00
210401	Бичиг хэрэг	9,344,890.00	11,246,090.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,961,800.00	5,174,765.00
210404	Ном, хэвлэл	00.00	600,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон ариутгал	600,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	9,494,539.38	4,858,260.00
2105	Нормативд зардал	485,000.00	365,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	485,000.00	365,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,656,200.00	9,247,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,656,200.00	1,247,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00
2107	Томиллот, зочны зардал	746,000.00	2,421,800.00

210702	Дотоод албан томилолт	746,000.00	2,421,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,067,462.00	3,722,396.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,203,220.00	1,877,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	614,400.00	1,737,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	40,788.00	52,614.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	22,054.00	10,582.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,499,756.27	51,379,337.83
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,499,756.27	51,379,337.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,657,768.00	63,365,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	46,647,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	46,497,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,657,768.00	16,718,250.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,657,768.00	16,718,250.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	37,968,129.35	150,919,197.17
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	37,968,129.35	150,919,197.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	510,562,800.00	691,556,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,000,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	4317143.0
120009	Бусад орлого	00.00	1,000,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	510,562,800.00	690,556,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	510,562,800.00	690,556,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	510,562,800.00	690,556,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	500,719,900.00	689,413,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,719,900.00	689,413,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	492,062,132.00	626,048,150.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,528,450.00	484,048,017.00
210101	Үндсэн цалин	284,413,588.00	334,979,125.00
210102	Нэмэгдэл	69,283,397.00	112,113,072.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,238,569.00	13,317,031.00
210104	Урамшуулал	16,592,896.00	23,638,789.00
2102	Ажил олгогчоос НДШ	49,831,820.00	60,404,951.00
210201	Тэтгэврийн даатгал	34,583,669.00	41,253,049.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,875,141.00	4,816,146.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,071,703.00	3,852,875.00
210204	Ажилгүйдлийн даатгал	754,665.00	953,031.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,546,642.00	9,529,850.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	24,869,500.00	36,775,101.00
210301	Гэрэл, цахилгаан	3,077,630.00	3,196,900.00
210302	Түлш, халаалт	20,173,952.00	31,342,851.00
210303	Цэвэр, бохир ус	1,617,918.00	2,235,350.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,876,800.00	27,818,885.00
210401	Бичиг хэрэг	8,718,300.00	14,389,250.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,961,800.00	5,174,765.00
210404	Ном, хэвлэл	00.00	600,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, ариутгал	600,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,596,700.00	4,154,870.00
2105	Нормативт зардал	485,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	485,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,657,100.00	9,357,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,657,100.00	1,357,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	746,000.00	2,421,800.00
210702	Дотоод албан томилолт	746,000.00	2,421,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,067,462.00	3,722,396.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,203,220.00	1,877,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	614,400.00	1,737,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	40,788.00	52,614.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	22,054.00	10,582.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,657,768.00	63,365,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	46,647,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	46,497,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,657,768.00	16,718,250.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,657,768.00	16,718,250.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	9,842,900.00	2,143,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,842,900.00	1,143,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,842,900.00	1,143,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,842,900.00	1,143,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,842,900.00	1,143,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,842,900.00	-1,143,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	

Архив
 2015.12.31
 13998
 МКОА0065
 9055436

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	155,648,199.00	255,251,058.25	101,796,270.03	512,695,527.28
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	155,648,199.00	255,251,058.25	101,796,270.03	512,695,527.28
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	37,968,129.35	37,968,129.35
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	155,648,199.00	255,251,058.25	139,764,399.38	550,663,656.63
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	155,648,199.00	255,251,058.25	139,764,399.38	550,663,656.63
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	155,648,199.00	255,251,058.25	139,764,399.38	550,663,656.63
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	150,919,197.17	150,919,197.17
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	155,648,199.00	255,251,058.25	290,683,596.55	701,582,853.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан


Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4317143938
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	691,046,700.00	673,838,450.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	691,046,700.00	673,838,450.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	691,046,700.00	627,191,150.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,245,900.00	484,048,017.00
210101	Үндсэн цалин	333,864,100.00	334,979,125.00
210102	Нэмэгдэл	128,067,800.00	112,113,072.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,444,000.00	13,317,031.00
210104	Урамшуулал	14,870,000.00	23,638,789.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,530,800.00	60,404,951.00
210201	Тэтгэврийн даатгал	41,840,900.00	41,253,049.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,922,500.00	4,816,146.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,938,000.00	3,852,875.00
210204	Ажилгүйдлийн даатгал	984,500.00	953,031.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,844,900.00	9,529,850.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,237,900.00	36,775,101.00
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	3,196,900.00
210302	Түлш, халаалт	33,137,900.00	31,342,851.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	2,235,350.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,778,400.00	27,818,885.00
210401	Бичиг хэрэг	9,069,000.00	14,389,250.00
210402	Тээвэр, шатахуун	7,493,600.00	3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,115,800.00	5,174,765.00
210404	Ном, хэвлэл	600,000.00	600,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,900,000.00	4,154,870.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,500,000.00	10,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00

2107	Томилолт, зочны зардал	2,421,800.00	2,421,800.00
210702	Дотоод албан томилолт	2,421,800.00	2,421,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,334,600.00	3,722,396.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,448,000.00	1,877,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,737,700.00	1,737,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,900.00	52,614.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	33,000.00	10,582.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,007,300.00	46,647,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,497,300.00	46,497,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	510,000.00	150,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	691,046,700.00	673,838,450.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	691,046,700.00	673,838,450.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	691,046,700.00	673,838,450.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	22.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар нь “Шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй хүргэх” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.



Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, хамгаалах,
- Шүүхийн зохион байгуулалт, захиргаа, хүний нөөцийг удирдах,
- Төсвийг төлөвлөх, санхүү, дэд бүтцийг удирдах,
- Шүүгчдийг мэдээллээр хангах, олон нийттэй харилцах
- Олон нийттэй ил тод, нээлттэй харилцах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн 2022 оны 04 дүгээр сарын 22-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний 193 дугаар тогтоолоор албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ШЕЗ-ийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар нь ШЕЗ-ийн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 174 дүгээр тушаалаар баталсан "ШЕЗ-ийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 150,919.2 мянган төгрөгөөр буюу 27.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

		/мянган төгрөгөөр/		
	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	Б	1	2	3=2-1
1	Мөнгөн хөрөнгө		1,000,000.0	1,000,000.0
2	Авлага			
3	Урьдчилж гарсан зардал			
4	Бараа материал	7,756.19	11,738.30	3,982.11
5	Үндсэн хөрөнгө	542,907.45	688,844.54	145,937.09
6	Нийт хөрөнгө	550,663.65	701,582.85	150,919.20
7	Өр төлбөр	-	-	-
8	Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч/	550,663.65	701,582.85	150,919.20
9	Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	550,663.65	701,582.85	150,919.20

Бараа материалын дансны үлдэгдэл 11,738.3 мянган төгрөг болж 3,982.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 32,501.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, ШЕЗ-өөс 1,297.3 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан зэргээр нэмэгдэж, 29,816.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 868,401.6 мянган төгрөг болж 197,316.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,143.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 190,936.5 мянган төгрөгийн сантехникийн засварыг капиталжуулж бүртгэсэн, 5,046.9 мянган төгрөгийн принтер, IP сүлжээний гадна, дотор камер зэрэг тоног төхөөрөмж, 190.0 мянган төгрөгийн номыг ШЕЗ-ийн даргын 2022 оны 130 дугаар тушаалаар үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 701,582.8 мянган төгрөг болж 150,919.2 мянган төгрөгөөр өссөн нь нийт хөрөнгийн өсөлт, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 654,712.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 16,464.0 мянган төгрөгийг бууруулан 638,248.0 мянган төгрөгөөр баталсан нь урсгал засварын зардлаас барилгын сантехникийн засварын төсвийг хасаж баталсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 50,308.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, төсвийг 690,556.7 мянган төгрөгөөр эцэслэн баталсан нь Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалин нэмэгдсэнээр цалингийн зардлыг 82,308.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, аудит баталгаажуулах зардлыг 250.0 мянган төгрөгөөр бууруулан баталсантай холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 690,556.7 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 690,556.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 673,838.4 мянган төгрөгийг зарцуулан 16,718.25 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 673,838.4 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 13,297.7 мянган төгрөгөөр, зөвлөл хороо комиссын гишүүдийн зардлыг 2,570.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийг 850.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

дд	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл тийн хувь
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	639,559.40	626,261.65	13,297.75	97.8
2	Зөвлөл хороо комиссын гишүүд	3,500.00	929.50	2,570.50	26.5
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	47,497.30	46,647.30	850.00	98.2
4	Дүн	690,556.70	673,838.45	16,718.25	97.4

/мянган төгрөгөөр/
Биелэл
4317443998
100130905501

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130905501 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 546,743.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,467.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ШЕЗ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 1-ний 01/212 дугаар "Төсвийн жилд хэрэгжүүлэх чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийг хэрэгжүүлж, төсвийг зохистой хэмнэлттэй удирдаж, авлага, өглөг үүсгэлгүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сайхан сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар нь мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай **нийцсэн** гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 12,828.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 1 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	12,828.5	1	12,828.5	100%
Нийт дүн	1	12,828.5	1	12,828.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,558.5 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:



1. Төрийн албан хаагчийн урамшуулал давхардуулан олгосонтой холбоотой асуудал.

1.1 Илрүүлэлт: Нягтлан бодогч Д.Алтангэрэлийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40.0 хувиар тооцож олгосон боловч ШЕЗ-ийн даргын 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 187 дугаар тушаалаар 2021 оны ажлыг "Хангалттай" үнэлүүлсэн гэх үндэслэлээр 2 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,595.3 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 : "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийг үр дүн, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, нэг ажлын үр дүнгээр урамшууллыг давхардуулан олгохгүй байх.

2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Жилийн эцэст төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэлгүйгээр бичиг хэргийн зардлын хэмнэлт болох 2,963.2 мянган төгрөгөөр бичгийн цаас, принтерийн хор, албан бланк худалдан авч нөөцөлсөн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн 7.7 дахь "...Төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгийн үлдэгдлийг 2023 оны батлагдсан төсвөөс тооцож, татан төвлөрүүлэх

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон	1	1,595.3					1	1,595.3				
Төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлээгүй	1	2,963.2					1	2,963.2				
Дүн	2	4,558.5					2	4,558.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								